



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/14

Хужирт сум

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 2.2, 2.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээг саадгүй явуулах, хүн, амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэт-Булган Цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компаний эзэмшлийн 35/10/0,4/0,22кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/10,10/0,4кВ-ын дэд станцын хамгаалалтын зурвасыг хавсралтаар тогтоосугай.
2. Хамгаалалтын зурваст газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх үйл ажиллагаа хийхгүй байхыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.
3. Хамгаалалтын зурваст дэглэм сахиулах, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах ажлыг хариуцан ажиллахыг Эрчим хүчний эрхлэгч (С.Цэрэндаваа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ